

ЖЕНДЕРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ЗАР

Төслийн дугаар: 48076-002

Төслийн нэр: L3605/G9191-МОН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД:

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын Засгийн газар (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх замаар нийгмийн болон эрхийн асуудлыг нь шийдвэрлэхэд Монгол улсын Засгийн Газарт дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Төслийн эцсийн зорилго нь ХБИ-ний бие даах чадварыг дээшлүүлж, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Төсөл нь 5 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Илүү мэдээллийг <https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>-аас авна уу.

Мэргэжилтэн нь дараах ажлыг гүйцэтгэнэ:

- Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэх;
- Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилсан жендерийн асуудлуудыг хэрэгжүүлэх, хянах болон тайлагнахад чиглэсэн удирдлагын хяналтын механизмуудыг байгуулахад ТХН-д туслах, тэдгээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Шаардлагатай семинар болон зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулах замаар Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шаардлагуудыг хэрэгжүүлэхэд нь ТХН-д туслалцаа үзүүлэн хамтран ажиллах;
- Жендерийн тодорхой үзүүлэлтүүдийг үнэн зөв цуглуулах, хянах, хураангуй тайланд эдгээр үзүүлэлтүүдийн талаар тусгаж ажиллах;
- Нийгэм болон жендерийн асуудлуудын хэрэгжилтийн хянаж, Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй зөвлөхүүдтэй харилцан хамтран ажиллах, холбогдох баримтуудыг хянаж үнэлэх, шаардлагатай тохиолдолд залруулах арга хэмжээнүүдийг тодорхойлоход нь туслалцаа үзүүлэх;

Мэргэжилтэн нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жендерийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөнд тодорхойлсон тодорхой үзүүлэлтийн нийгмийн хөгжлийн хэсэг дэх хагас жилийн явцын тайлан болон жилийн хяналтын тайланг бэлтгэхэд ТХН-т дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

D. ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол: Нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр Мастер болон дүйцэхүйц зэрэгтэй байх.

Туришлага:

- Доод тал нь 5 жил жендер болон нийгмийн хөгжлийн чиглэлээр ажилласан туршлагатай байх;
- Олон улсын санхүүжилттэй төсөл дээр багадаа 3 жил ажилласан туршлагатай байх;
- Жендертэй холбоотой төсөл дээр багадаа 2 жил ажиллаж байсан туршлагатай байх.

Бусад ур чадвар:

- MS Office (Word, Excel, PowerPoint гэх мэт), веб хөтөч дээр ажиллах чадварыг эзэмшсэн байх,
- Мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн
- Харилцааны өндөр чадвартай
- Оролцогч талууд болон хэрэгжүүлэгч агентлагуудтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх
- Бие дааж болон багаар ажиллах чадвартай байх
- Зохион байгуулах болон олон ажлыг хийж гүйцэтгэх чадвартай байх

Хэлний мэдлэг: Англи хэлний ярианы болон бичгийн өндөр түвшний мэдлэгтэй байх;

Ажлын даалгавар болон бусад холбогдох мэдээллийг доорх цахим хаягаас авах боломжтой <http://csr.n.adb.org>. Оролцох сонирхол бүхий зөвлөхүүд өөрсдийн CV-ийг Англи хэл дээр АХБ-ны Зөвлөх менежментийн систем болох cms.adb.org хаягаар орж онлайнаар, эсхүл 1 эх хувь цаасан материалыг 2020 оны 3-р сарын 16-ны өдрийн 16:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар ажлын цагаар 9:00-17:00 цагийн хооронд авах боломжтой.

Материал хүлээн авах хаяг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн нэгж, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Макс цамхаг, 7 дугаар даврах 703 тоот

Холбогдох дугаар: 976-7733-5577

Цахим хаяг: bolortuya@pwpd.mn

